



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А-98

Улаанбаатар хот

Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалтыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.


2.Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалтыг шинэчлэх тухай саналыг тодорхой нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан тухай бүр боловсруулж, танилцуулахыг Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд даалгасугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-280 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1524011793

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 4-98 дугаар тушаалын хавсралт

ТӨВ БАНКНААС БАНКАНД ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХОД БАРЬЦААЛАХ  
ХӨРӨНГӨ БОЛОН РЕПО НӨХЦӨЛӨӨР ХУДАЛДАН АВАХ  
ҮНЭТ ЦААСНЫ ЖАГСААЛТ

1. Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө, репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаас

Зээл, санхүүжилтийн төрөл	Барьцаа хөрөнгө <sup>1</sup>
<b>1. Нээлттэй захын үйл ажиллагаа</b>	
1.1 Репо арилжаа	<ul style="list-style-type: none"><li>Төв банкны үнэт цаас</li><li>Засгийн газрын үнэт цаас</li><li>МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд</li></ul>
<b>2. Санхүүжилтийн байнгын хэрэгсэл</b>	
2.1 Репо санхүүжилт	<ul style="list-style-type: none"><li>Төв банкны үнэт цаас</li><li>Засгийн газрын үнэт цаас</li><li>МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд</li></ul>
2.2 Өдрийн репо зээл	<ul style="list-style-type: none"><li>Төв банкны үнэт цаас</li><li>Засгийн газрын үнэт цаас</li></ul>
<b>3. Барьцаат зээл</b>	<ul style="list-style-type: none"><li>Төв банкны үнэт цаас</li><li>Засгийн газрын үнэт цаас</li><li>Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаас<sup>2</sup></li><li>МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан давуу болон энгийн эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд</li><li>Үнэт цаас санхүүжилтийн корпораци ХХК-ийн байгуулсан ТЗК-иас гаргасан давуу эрхтэй хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас</li><li>Хэвийн зээл</li></ul>

<sup>1</sup> Репо хэлцэл хийх болон барьцаанд авах үнэт цаас нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй биет бус төгрөгөөр илэрхийлэгдсэн үнэт цаас байна

<sup>2</sup> Монгол Улсын Хөгжлийн банканд зээл, санхүүжилт олгох тохиолдолд тус банкны гаргасан үнэт цаасыг барьцаанд авахгүй, репо хэлцэл хийхгүй

2. Төв банкны барьцаа хөрөнгийн эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээ, хувиар<sup>3</sup>

2.1 Тогтмол купонтой үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)									
	0-1 жил	1-2 жил	2-3 жил	3-4 жил	4-5 жил	5-6 жил	6-7 жил	7-8 жил	8-9 жил	9-10 жил
Засгийн газрын үнэт цаас	0.5	3.0	5.0	6.0	7.0	8.0	9.0	10.0	11.0	12.0
Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаас <sup>4</sup>	11.0	14.0	16.0	18.0	19.0	-				
Давуу эрхтэй ИЗББ <sup>5</sup>	20.0									
Энгийн эрхтэй ИЗББ <sup>5</sup>	40.0									
Давуу эрхтэй хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас <sup>6</sup>	30.0									

2.2 Купонгүй үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)				
	0-1 жил	1-2 жил	2-3 жил	3-4 жил	4-5 жил
Төв банкны үнэт цаас	0.5	-			
Засгийн газрын үнэт цаас	0.5	-			
Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаас <sup>4</sup>	11.0	16.0	20.0	24.0	28.0

2.3 Банкны хэвийн зээлийн эрсдэлийн хямдруулалт

Зээлийн үлдэгдэл хугацаа	Эрсдэлийн хямдруулалт
3 жил хүртэл	30.0
3 жилээс дээш	50.0

<sup>3</sup> Төв банкнаас олгох санхүүжилтийн хэмжээг дараах томъёогоор тооцож, зуутын орон хүртэл бүхэлчилнэ.

$$F = C * \frac{100 - H}{100}$$

- F – Санхүүжилтийн хэмжээ
- C – Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ
- H – Эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээ

<sup>4</sup> Засгийн газрын баталгаатай Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаасны эрсдэлийн хямдруулалтыг ЗГҮЦ-ны эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээгээр тооцно

<sup>5</sup> МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд

<sup>6</sup> Үнэт цаас санхүүжилтийн корпораци ХХК-ийн байгуулсан ТЗК-иас гаргасан хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А-159

Улаанбаатар хот

Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А-98 дугаар тушаалаар баталсан “Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалт”-нд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсугай.

а. Жагсаалтын 1 дэх хэсгийн 1.1, 2.1, 3-т “Нийслэлийн үнэт цаас” гэж нэмэх.

б. Жагсаалтын 2 дахь хэсгийн 2.1-д дараах хэсгийг нэмэх.

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)				
	0-1 жил	1-2 жил	2-3 жил	3-4 жил	4-5 жил
Нийслэлийн үнэт цаас <sup>1</sup>	8.0%	10.0%	12.0%	14.0%	16.0%

<sup>1</sup> Нийслэлийн үнэт цаасыг Засгийн газрын баталгаатайгаар зах зээлд гаргасан нөхцөлд тус үнэт цаасны эрсдэлийн хямдруулалтыг ЗГҮЦ-ны эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээгээр тооцно

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1524011176



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А-284

Улаанбаатар хот

Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалт батлах тухай А-98 дугаар тушаалын хавсралтын 2 дахь хэсгийн 2.1-д дараах хэсгийг нэмсүгэй.

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)
	0-3 жил хүртэл
Монголын төмөр зам-ТӨХК-ийн үнэт цаас	30%

2. Энэхүү тушаалыг 2026 оны 12 дугаар сарын 02-ны өдрийг дуустал мөрдөж ажилласугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525012527



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/134.

Улаанбаатар хот

### Жагсаалтад нэмэлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А-98 дугаар тушаалаар баталсан “Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон репо нөхцөлөөр худалдан авах үнэт цаасны жагсаалт”-д дараах нэмэлтийг оруулсугай.

1/ Жагсаалтын 1 дэх хэсгийн 3-т “Аймгийн “Өмнөговь бонд” үнэт цаас” гэж нэмэх.


2/ Жагсаалтын 2 дахь хэсгийн 2.1-д дараах хэсгийг нэмэх.

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)				
	0-1 жил	1-2 жил	2-3 жил	3-4 жил	4-5 жил
Өмнөговь аймгийн “Өмнөговь бонд” үнэт цаас	10.0%	13.0%	15.0%	17.0%	18.0%

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зах зээл, валютын газар (П.Мөнхбаяр), Эрсдэлийн удирдлага, дотоод аудитын газар (Д.Баянзул), Санхүү, удирдлагын газар (Б.Батбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, дотоод аудитын газар (Д.Баянзул)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



С.НАРАНЦОГТ

1526010801